



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 30 өдөр

Дугаар A/49

Онги

Г Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай Г

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.8 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тус сумын Найз багийн нутаг “Их өндөр” гэх газар нутаглаж буй малчин Б.Шинэбаярын суурьт малын гоц халдварт бог малын мялzan өвчний шинж тэмдэг бүдгэрч эдгэрсэнтэй холбогдуулан 2023 оны 06 сарын 30-ны өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдрийг хүртэл дуусах хуганцаанд хязгаарлалтын дэглэм тогтоосугай.
2. Хязгаарлалтын дэглэм тогтоосон бүсээс гарах мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг хориглосугай.
3. Хязгаарлалтын дэглэм тогтоосон бүсэд хяналт тавьж, удирдлага мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (С.Болоржаргал), Мал эмнэлгийн улсын байцаагч (Ц.Саранчимэг) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЛУВСАНРАГВА